



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны III байр,
Ж.Самбуугийн гудамж 16, 4 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (976) 7777 1992

Цахим шуудан: info@chingeltei.gov.mn
Цахим хуудас: www.chingeltei.gov.mn

2024.06.14 № 3/1557

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Дүүргийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг зөөлөн эдлэл, хивс, дрожоор хангах төсөл арга хэмжээний хүрээнд 4 нэр төрөл буюу 1600 ширхэг иж бүрэн багц зөөлөн эдлэл, 2 нэр төрлийн буюу хивс 59 ширхэг, дрож 1000 метр барааг хүлээн авах тендерийг зарлуулсан. Тус тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

- 4м өргөнтэй 1000м дрожийн хуваарилалтыг цэцэрлэгийн хүртээмж, анги танхимын зохион байгуулалтаас хамаарч гэрээ байгуулах явцад мэдээллээр хангах болно.
- Дрожны түүхий эд материалын хувьд: 80% ноос 20% полиамадын холимог утастай, өргөн 4м, хүүхдийн биед харшил өгөхгүй нягтрал сайтай байх, дрожны ар хэсэг нь халтирч гулгахгүй аюул багатай, гал дэмждэггүй байх.
- Хивсний түүхий эд материалын хувьд: Эрдэнэт хивс-Хүннү брэнд түүнтэй дүйцэхүйц байх, 100% цэвэр ноосон утастай, нягтрал сайтай хүүхдийн биед харшил өгөхгүй, халтирах гулгах аюул багатай, гал дэмждэггүй байх.
- Түгээлтийн хувьд гэрээ байгуулах явцад мэдээллээр хангах болно.
- Савлагааны хувьд баглаа боодол нь ГТН-д заасан баглаа боодлын шаардлагыг хангасан байна. Зөөлөн эдлэл нь иж бүрнээр багцалсан зориулалтын уут савтай байна.



Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Дарга
Жавзий Лхагвасүрэн
2024.06.14 15:23